



**ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2021 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний
тухай

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 10-ны А/129 дугаар тушаал, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Зам, тээврийн салбарын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө болон Төвийн өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийг сар бүрийн 25-ны дотор Төвийн захирал болон Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг /С.Золзаяа/-д даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/42 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ



А БУЯННЭМЭХ

000866

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2021 оны
08 дугаар сарын 21-ний өдрийн 173 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт




Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	С.Золзаяа	Нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга:	Д.Пүрэвдолгор	Дотоод үйл ажиллагааны мэргэжилтэн, нярав
Гишүүд:	Р.Мягмарсүрэн	Статистик мэдээлэл, тээвэрлэлтийн үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Э.Энхцэцэг	Тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын ахлах мэргэжилтэн
	З.Мөнхтуяа	Хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, чингэлэг бүртгэлийн мэргэжилтэн

___оо___

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2021 оны
08 дугаар сарын 27-ний өдрийн 40 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн
2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Шаардагдах хөрөнгийн эх үүсвэр	Хариуцагч
1	Байгууллагын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах, хяналт тавих, дүгнэн ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг томилон ажиллуулж, байгууллагын өвөлжилтийн бэлтгэл хангах дэлгэрэнгүй төлөвлөгөөг батлан мөрдөж ажиллах	2021.08.25-ны дотор	Төвийн зардлаар	С.Золзаяа Д.Пүрэвдолгор
2	Дулааны цахилгаан станцуудын 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах хүрээнд 20-иос доошгүй хоногийн нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай тээвэрлэлтийн зохион байгуулалтыг хэрэгжүүлэх, хяналт тавих	2021 оны 10 дугаар сард	Тухайн байгууллагын зардлаар	Р.Мягмарсүрэн Э.Энхцэцэг
3	Төвийн ажлын байрны их болон урсгал засвар, дулаалгыг бүрэн хийж өвөлжилтөд бэлтгэх	2021 оны III улирлын дотор	Төвийн зардлаар	Д.Пүрэвдолгор
4	Төвийн авто тээврийн хэрэгслийг өвлийн тээвэрт бэлтгэх	2020 оны 11 дүгээр сард	Төвийн зардлаар	Д.Бат-Оргил
5	Осол, техникийн гэмтэл, цаг агаарын хүндрэл, байгалийн гамшиг гарсан үед Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны “Мэдээллийн схем баталж, мэдээлэл дамжуулах тухай” 235 дугаар тушаалын дагуу ажиллах	Тухай бүр	Төвийн зардлаар	Р.Мягмарсүрэн З.Мөнхтуяа
6	Улаанбаатар хотыг сайжруулсан түлшээр хангах тээврийн төлөвлөгөөг галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгах	2021 оны 10 дугаар сар	Төвийн зардлаар	Э.Энхцэцэг Г.Билгүүн
7	Өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах ажлыг зохион байгуулах	Тогтмол	Төвийн зардлаар	Д.Пүрэвдолгор Д.Амарзаяа
8	Албан хаагчдыг өвөлд бэлтгэх, онцгой үед ажиллах, мэдээлэл шуурхай дамжуулах зохион байгуулалт, техникийн бэлэн байдлыг хангах зэрэг чиглэлээр холбогдох албан хаагчдад сургалт зохион байгуулах	2021 оны 10 дүгээр сард	Төвийн зардлаар	Д.Пүрэвдолгор З.Мөнхтуяа
9	ДЦС-ын өвлийн бэлтгэлд шаардлагатай нүүрс тээвэрлэх төлөвлөгөөг галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт тусгах	2021 оны 10 дугаар сард	Төвийн зардлаар	Э.Энхцэцэг З.Мөнхтуяа
10	Төлөвлөгөөний биелэлтийг ЗТХЯ-нд сар бүрийн 25-ны дотор хүргүүлэх	2021.08.25-2022.04.25-ныг дуустал сар бүр	Төвийн зардлаар	Д.Пүрэвдолгор